



БАЯНХОНГОР АЙМАГ
БААЦАГААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 14 өдөр

Дугаар А/2

Баянсайр

Хамтарсан багийн гишүүдийн чиг үүргийг тодорхой болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 2 дугаар бүлэг, Хамтарсан багийн ажиллах, үйл ажиллагааг санхүүжүүлэх журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хамтарсан багийн гишүүдийн чиг үүргийг хавсралтаар баталсугай.
2. Багийн гишүүн тус бүр чиг үүрэгт заасан үйл ажиллагаагаа хэрэгжүүлж, улирал тутмын сүүлийн сарын 25-ны дотор тайланг Нарийн бичгийн дарга (Б.Отгонжаргал)-д ирүүлж байхыг үүрэг болгосугай.
3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Бямба-Ням)-д даалгасугай.

ДАРГА



С.ЭНХТӨР

642101279

Засаг даргын 2022 оны 01 дугаар сарын 22 ны өдрийн 11/М дугаар захирамжийн хавсралт

СУМЫН ХАМТАРСАН БАГИЙН ГИШҮҮДИЙН ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаал	Чиг үүрэг	Хуулийн үндэслэл
1	2	3
Багийн ахлагч /Сумын Засаг дарга/	<p><u>Үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Харьяалах нутаг дэвсгэртээ гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль тогтоомжийг сурталчлах, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах, хүчирхийллийн шалтгаан, нөхцөлийг тогтоох, арилгах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх 2. Хамтарсан багийг нэгдсэн удирдлагаар хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх 3. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр байгуулах саналаа иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах 4. Орон нутгийн эдийн засаг, нийгмийн үндсэн чиглэл болон төсөвт гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаа, түүнд шаардагдах зардлын төсөв, ойрын ба хэтийн төлөвийг тодорхойлсон хөтөлбөрийн төсөл боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах 5. Хохирогчид үйлчилгээ үзүүлэхтэй холбостой зардлыг төсөвт тусгуулах саналыг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх, гүйцэтгэлийг тайлагнах 6. Хохирогчид үйлчилгээ үзүүлэх ажлыг харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулах, нийгмийн ажилтныг хохирогчтой ганцаарчлан уулзах өрөө, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх 7. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг дэмжих, гэрээний үндсэн дээр санхүүжүүлэх 8. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах <p><u>Хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Хүчирхийлэл үйлдэгчийг дуудан ирүүлж, шаардлага тавих, сануулга өгөх 2. Хохирогчийг эмнэлгийн яаралтай тусламжид холбох, шаардлагатай бол хохирогчийн байгаа орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, боломжтой бол хохирогчийг тэрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгөх 3. Хохирогчид эрх, үүргийг нь тайлбарлаж, түүнд үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээллээр хангах 4. Хохирогчийн зөвшөөрснөөр нийгмийн ажилтанд 	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 19 дүгээр зүйл</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 24 дүгээр зүйл</p>

	<p>мэдэгдэх</p> <p>5. хүчирхийлэл үйлдэгдсэн тухай хохирогч, хүчирхийлэл үйлдэгч, гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах</p> <p>5. Нөхцөл байдлын талаар цагдаагий албан хаагчид мэдэгдэж, холбогдох тэмдэглэлийг шилжүүлэх</p>	
<p>Нарийн бичгийн дарга /Нийгмийн бодлогын мэргэжилтэн/</p>	<p><u>Үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Багийн гишүүдийн үүргийг хуваарилах, оролцоо, үр дүнг хянах 2. Хамтарсан арга хэмжээ болон нийгмийн үйлчилгээний зардал, тайлан мэдээнд үндэслэн дараа жилийн үйлчилгээнд шаардагдах төсөв хөрөнгийг орон нутгийн төсөв болон бусад төсөлд суулгах санал боловсруулж, Засаг даргад танилцуулах <p><u>Хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Хохирогчийг мэдээллээр хангах, сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх 2. Гэр бүлийн хүчирхийллийн нөхцөл байдлыг үнэлэх 3. Нөхцөл байдлын үнэлгээнд үндэслэн хохирогчийн хэрэгцээг тодорхойлж, хамтарсан багаар үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах 4. Хохирогчийг асрамж, халамжийн хувилбарт үйлчилгээ болон нийгмийн халамжийн тэтгэмжид хамруулах, шаардлагатай бусад үйлчилгээнд холбон зуулгах үйлчилгээг зохион байгуулах 5. Хүчирхийллийн болзошгүй эрсдэлд байгаа хүүхэд, гэр бүлийг илрүүлэх судалгааг холбогдох албан хаагчдаар гаргуулах, бүртгэл хөтлөх, үйл ажиллагаандаа ашиглах 6. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгааг зохион байгуулах 7. Хохирогчид вэзүүлэх хамтарсан багийн үйлчилгээг төлөвлөх, уялдуулан зохицуулах 	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 26.1 дүгээр зүйл</p> <p>Хүүхэд хамгааллын тухай хуулийн 19 дүгээр зүйл</p>
<p>Хөдөлмөр халамж хариуцсан мэргэжилтэн</p>	<p><u>Үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Халамжид хамрагдах өрх, иргэний тоо болон хэрэгцээний судалгаа гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх 2. Нийгмийн халамжид хамрагдах өрх, иргэний нөхцөл байдлыг үнэлж, хөгжлийн төлөвлөгөөг тухайн өрх, иргэнтэй хамтран хийж хэрэгжүүлэх 3. Нийгмийн халамжийн болон нийгмийн хөгжлийн үйлчилгээнд хамрагдах өрх, иргэнийг тодорхойлж шийдвэрлүүлэх 4. Өрх, иргэдийг хүсэл, зорилго, хэрэгцээгээрээ бүлэг болгон зохион байгуулагдахад нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх 5. Өрх, иргэдийг амьжиргаагаа дээшлүүлэх чадавхтай болоход нь туслах зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах 6. Хүн ам, гэр бүлийн хөгжлийг дэмжих чиглэлээр батлагдсан үндэсний хөтөлбөр, арга хэмжээг орон нутагтаа хэрэгжүүлэх ажлыг эрүүл мэндийн, боловсролын болон бусад нийгмийн ажилтантай хамтран зохион байгуулах 7. Иргэнийг нийгмийн халамжийн үйлчилгээнд үр 	<p>Нийгмийн халамжийн тухай хуулийн 28 дугаар зүйл</p>

	<p>дүнтэй хамруулах зорилгоор эрүүл мэнд, боловсролыг дэмжих зэрэг нийгмийн хөгжлийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагатай зуучилж өгөх</p> <p><u>Хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй хүүхэд, иргэн, албан хаагчийн талаар мэдсэн бол холбогдох албан хаагчид заавал мэдээлэх 2. Нарийн бичгийн дарга эзгүй үед хүүхэд, гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээг хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллах 	
<p>Эрүүл мэндийн нийгмийн ажилтан</p>	<p><u>Үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Үйлчлүүлэгчийн нийгэм-сэтгэл зүйн тулгамдсан асуудлыг судлан, хэрэгцээ, давуу тал, нөөцөд тулгуурлан үйлчилгээг төлөвлөх, хүргэх, үнэлэх 2. Эрсдэлт бүлгийн иргэдэд /нэн ядуу, хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, ХДХВ-ийн халдвартай хүмүүс, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, хүчирхийлэлд өртсөн хохирогч г.м/ эрүүл мэндийн нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай үйлчилгээнд холбон зуучлах 3. Эмнэлгийн хяналтанд байдаг үйлчлүүлэгч /архинд донтсон, сэтгэцийн эмгэгтэй г.м/, тэдний гэр бүлд нийгэм-сэтгэл зүйн тулгамдсан асуудлаа даван туулахад зөвлөгөө өгөх 4. Үйлчлүүлэгчдийн дунд өвчний явц хэлбэрээс хамааруулан нийгэм-сэтгэл зүйн асуудлыг /сэтгэл гутрал, сэтгэл түгшил, стресс, хөдөлгөөнийг идэвхийг дэмжих г.м/ даван туулахад чиглэсэн өөртөө туслах, дэмжих бүлэг зохион байгуулах, чиглүүлэх, идэвхжүүлэх 5. Эрүүл мэндийн тулгамдсан асуудалтай үйлчлүүлэгч /хавдар, сүрьеэ, ХДХВ, ДОХ, архинд донтох г.м/-ийн тулгамдсан нийгэм, сэтгэл зүйн асуудлыг шийдвэрлэх, зан үйлийг өөрчлөх, эрүүл зан үйл төлөвшүүлэх зорилгоор заслын, дэмжих, өөртөө туслах бүлэг ажиллуулах <p><u>Хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийг илрүүлэх, холбогдох байгууллагад мэдээлэх, хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгааныг тэмдэглэж, баримтжуулах 2. Хохирогчийг шаардлагатай үйлчилгээний талаарх мэдээллээр хангах 3. Хохирогчийн бэртэл гэмтэл, өвчлөлийн шалтгаанд мэргэжлийн дүгнэлт гаргах 	<p>Эрүүл мэндийн сайдын 2018 оны 07 дугаар сарын 18-ны өдрийн А/289 дугаар тушаал</p> <p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 27 дугаар зүйл</p>
<p>Сургуулийн нийгмийн ажилтан</p>	<p><u>Үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Суралцагч, эцэг эх болон багшийн харилцаа, тэдний нийгмийн асуудлаар үнэлгээ хийх 2. Ганцаарчилсан болон бүлэгт чиглэсэн мэргэжлийн зөвлөгөө өгөх замаар нийгмийн сөрөг үзэгдлээс хүүхдийг урьдчилан сэргийлэх 3. Суралцагчдын төлөвшил, хамтын ажиллагаанд дэмжлэг үзүүлэх 	<p>Боловсролын тухай хуулийн 3.1.12 дугаар зүйл</p>

	<p>4. Сургууль дээр болон сургуулийн ойр орчимд хүчирхийлэл гарахаас урьдчилан сэргийлэх хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх/ сургуулийн байршил, сурагчдын онцлог зэргээс хамаарч хичээлд ирэх, тарах үеийн аюулгүй байдлыг хангах, орчны гэрэлтүүлэг, үе тэнгийнхний хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зэрэг хөтөлбөр хэрэгжүүлэх</p> <p>5. Эцэг эх багш нарт хүүхдийг хүмүүжүүлэх зэрэг арга барилын талаар мэдээлэл, сургалт зохион байгуулах.</p> <p><u>Хүчирхийллийг таслан зогсоох, хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд:</u></p> <ol style="list-style-type: none"> 1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үйлчилгээ үзүүлэх, нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх чиглэлээр санаачлага гарган ажиллах 2. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, туслалцаа, дэмжлэгийн талаар эцэг, эх, багш, холбогдох бусад ажилтан зөвлөгөө өгөх 3. Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурагч, багш, боловсролын байгууллагын бусад ажилтан, эцэг эхэд мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах 4. Боловсролын байгууллагын сургалтын орчин, дотуур байранд хүчирхийллээс урьдчилан сэргийлэх журам баталж, хэрэгжилтэд хяналт тавих 5. Зөрчлийг хүчирхийллийн бус аргаар шийдвэрлэх, эрсдлээс өөрийгөө хамгаалах мэдлэг, харилцааны ур чадвар олгох 6. Гэр бүл, олон нийт, сургуулийн хамтын ажиллагааг бэхжүүлэх ажлыг санаачлан зохион байгуулах. 7. Үндсэн чиг үүргийнхээ хүрээнд холбогдох хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх 	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай зүйлийн 26.2 дугаар зүйл</p>
<p>Цагдаагийн ажилтан</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хүчирхийлэл үйлдэгч, хохирогчийн талаархи бүртгэл хөтлөх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, ашиглах 2. Гэр бүлийн хүчирхийллийн мэдээллийг хүлээн авч, шаардлагатай тусламж үйлчилгээнд холбон зуучлах, зөвлөгөө өгөх утас 24 цагаар ажиллуулах 3. Аюулын зэргийн үнэлгээ хийх, нийгмийн ажилтанд мэдээлэх 4. Хохирогчийн аюулгүй байдлыг хангах 5. Цагдаагийн албан хаагч гэр бүлийн хүчирхийллийг таслан зогсоох зорилгоор бусдын орон байранд нэвтрэн орж хохирогч, түүний гэр бүлийн гишүүдийн аюулгүй байдлыг шалгах, аюулын зэргийн үнэлгээнд үндэслэн хохирогчийг түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвд хүргэх боломжтой бсл төрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгөх 6. Хүчирхийлэл үйлдэгчид хүчирхийлэл үйлдэх, согтууруулах ундаа хэрэглэхийг зогсоохыг шаардах 7. Хохирогчид хуульд заасан эрх, үүргийг нь 	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйл</p>

	<p>тайлбарлаж, түүнд үзүүлэх үйлчилгээний талаархи мэдээллийг бичгээр өгөх</p> <ol style="list-style-type: none"> 8. Хохирогчийн эрхийг хангах арга хэмжээ авах 9. Шаардлагатай бол хүчирхийлэл үйлдэгчийг баривчлах 10. Галт зэвсэг, хүчирхийлэл үйлдэхэд ашигласан зэвсэг, зэвсгийн чанартай зүйлийг хураан авах 11. Шаардлагатай бол гэрч, хохирогч, мэдээлэл өгсөн этгээд, тэдгээрийн гэр бүлийн бусад гишүүн, хохирогчид туслалцаа үзүүлсэн хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан арга хэмжээг авах 12. Тавьсан шаардлагыг хүчирхийлэл үйлдэгч биелүүлэхээс татгалзсан, эсхүл эсэргүүцсэн бол албадлага хэрэглэнэ. 13. Хохирогчид орон байрнаасаа хувцас, эм, эмнэлгийн хэрэгсэл, баримт бичиг, хүүхдийн сургалтын хэрэгсэл, шаардлагатай хэрэглээний эд зүйлээ авахад нь туслалцаа үзүүлж, хүчирхийлэл үйлдэгчээс шаардан гаргуулна. 	
<p>Төрийн бус байгууллагын төлөөлөл</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хамтарсан багийн гишүүдийг чадавхижуулах, мэргэжил арга зүйгээр хангахад дэмжлэг үзүүлэх 2. Олон нийтэд гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаархи мэдээлэл түгээх, сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах 3. Ажил үүргээ гүйцэтгэх явцдаа хүчирхийлэлд өртсөн, өртсөн байж болзошгүй хүүхэд, иргэн, албан хаагчийн талаар мэдсэн бол холбогдох албан хаагчид заавал мэдээлэх 	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйл</p>
<p>Багийн Засаг дарга нар</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хүчирхийлэл үйлдэгчийг дуудан ирүүлж, шаардлага тавих, сануулга өгөх 2. Хохирогчийг эмнэлгийн яаралтай тусламжид холбох, шаардлагатай бол хохирогчийн байгаа орон байрны аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авах, боломжтой бол хохирогчийг төрөл, садан, ойр дотны хүний түр хамгаалалтад өгөх 3. Хохирогчид эрх, үүргийг нь тайлбарлаж, түүнд үзүүлэх үйлчилгээний талаархи мэдээллээр хангах 4. Хохирогчийн зөвшөөрснөөр нийгмийн ажилтанд мэдэгдэх 5. хүчирхийлэл үйлдэгдсэн тухай хохирогч, хүчирхийлэл үйлдэгч, гэрчээс асууж, тэмдэглэл хөтлөх, шаардлагатай бусад ажиллагаа явуулах 6. Нөхцөл байдлын талаар цагдаагий албан хаагчид мэдэгдэж, холбогдох тэмдэглэлийг шилжүүлэх 7. Шаардлагатай мэдээ, судалгааг үнэн зөв гаргаж өгөх 8. Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг баг дээрээ зохион байгуулах 	<p>Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 24 дүгээр зүйл</p>
<p>Нийтлэг чиг үүрэг</p>	<ol style="list-style-type: none"> 1. Хувь хүний нууцыг чандлан хадгалж, албаны бус зорилгоор нийтэд дэлгэхгүй байх 2. Хүчирхийллийн нөхцөл байдлыг мэдсэн, илрүүлсэн тохиолдолд заавал холбогдох албан хаагчдад мэдэгдэх 3. Урьдчилан сэргийлэх сургалт, нөлөөллийн ажлыг хийх 4. Холбогдох хууль эрх зүйг сайтар судлах 5. Шаардлагатай судалгаа, мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв гаргаж өгөх 	